



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/206

Булган сум



Газрын хэмжээг өөрчилж, үнээр нь
өмчлүүлэх тухай



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6.1, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 324 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын иргэн Пүрэвсүрэн овогтой Мөнхбат (ГП70021412)-ын 000242207 дугаартай газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй Булган сум 3 дугаар баг Дунд агуйт 1 дүгээр гудамж 109 тоот байршилтай 6308000941 нэгж талбар бүхий 456 м2 газрыг сумын өнгө үзэмж сайжруулах ажлын хүрээнд нүүрний гудамжийг тэгшилсэнтэй холбогдуулан кадастрын зураглалын дагуу 598 м2 болгож, илүү талбай 142 м2 газрын үнэ 497,000 (дөрвөн зуун ерэн долоон мянга) төгрөгийг төлүүлэн, газрын хэмжээг өөрчилж, үнээр нь өмчлүүлсүгэй.

2.Иргэн П.Мөнхбатын өмчлөлийн газрын өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд хийж, газар өмчлөлд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/48 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР